



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/89

Цагаан-Уул сум

Г Авто тээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын үзлэг тооллого явуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/160 дугаар захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 оны авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг тооллогыг зохион байгуулах сумын салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Д.Түмэнбаяр (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ш.Эрдэнэцэцэг (Санхүү албаны дарга)

Ж.Бадрал (Архив албан хэрэг хөтлөгч)

А.Энхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

М.Лхагвадорж (Хэсгийн цагдаа)

Г.Маналжав (Агар багийн Засаг дарга)

Б.Дэлгэрмөрөн (Өвгөд багийн Засаг дарга)

Н.Доржпалам (Тосон багийн Засаг дарга)

Ч.Дэрмэн (Хужирт багийн Засаг дарга)

Б.Бямба-Эрдэнэ (Шарга багийн Засаг дарга)

Г.Ууганбаяр (Жаргалант багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат (Татварын улсын байцаагч)

2. Салбар комисст даалгах нь:

2.1 Сумын хэмжээнд тээврийн хэрэгслийн үзлэг тооллого зохион байгуулах салбар комиссоос өгсөн үүрэг даалгаварыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлэхээс татгалзсан тохиолдолд холбогдох журмын дагуу арга хэмжээ авах.

2.2 Авто тээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдасныг үндэслэн авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах.

2.3 Сум багт ашиглагдахгүй, хөдөлгөөнд оролцохгүй байгаа тээврийн хэрэгслүүдийн судалгааг гаргаж улсын бүртгэлээс хасуулах.

2.4 Сум багт байгаа авто машин, чиргүүл, трактор, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн бүртгэл судалгааг гаргаж тээврийн хэрэгслийг үзлэгт бүрэн хамруулах тал дээр онцгой анхаарч ажиллах.

3. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгийг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, аймгийн Засаг даргын баталсан хяналт шалгалтын ажлын удирдамжийн дагуу ажиллахыг салбар комисс (Д.Түмэнбаяр)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д даалгасугай.

ДАРГА  СГОНЧИГНЯМ